


МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батсүх	Дугаар	Л344
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Дэлгэрхангай сум
Төрсөн газар	Дэлгэрхангай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тус хийдийн хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хошуу хурал, Далхын хурал	Сүм хийдийн дугаар	ДУДХ 017, ДУДХ 009
Одоогийн сүм хийд	Дашчойнхорлин хийд	Сүм хийдийн дугаар	ДУДХ 008
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 25	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Шинэ Дашчойнхорлин хүүчний Хошуу хурлын хийд, Далхын хурлын тухай

Жужа: Шинэ хийд хэзээ байгуулагдсан бэ?

Батсүх: 1990 оны хаврын тэргүүн сарын шинийн найманд анх хурлаа хийсэн.

Жужа: Хэний санаачилгаар байгуулагдсан бэ?

Батсүх: Сүсэгтэн олны санаачилгаар, урд хошуу хийдэд гавж цолтой сууж байсан өндөр настан Цэрэннамжил гуайн идэвх санаачилгаар байгуулагдсан. Цэрэндорж, Дансран, Жанчив нарын арваад ламтайгаар анх байгуулагдсан.

Жужа: Тэгэхээр эдгээр лам нар бүгд урд өмнө лам авсан хүмүүс үү?

Батсүх: Тийм ээ, арваад ламын гурав дөрөв нь Хошуу хурлын хийдэд багадаа шавилж байсан хүмүүс юм гэнэ лээ.

Жужа: Тэгэхээр Хошуу хурлын хийд хичнээн ламтай хэр том хийд байсан юм бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батсүх: Өө анх мянган ламын данстай, 300-400 лам байнга хурж байгаад том хийд байсан юм гэнэ лээ. Энэ тухай судалгаа ч байдаг юм байна лээ. Гучаад дугантай, өвгөчүүл ч бас ярьдаг юм.

Жужа: Тэнд ямар ямар дуган дацан байсан бэ?

Батсүх: Мамба, жүд, гүрнэг, зурхай, дүйнхор зэрэг таван том дацан сургалттай байсан юм гэнэ лээ.

Жужа: Энэ хийд тэгээд хэдэн онд хаагдсан бэ?

Батсүх: За 1935 оноос хойш ерөөсөө хурал хураагүй гэж ярьдаг байсан.

Жужа: Одоо тэнд түүр, балгас ямар нэгэн мэдэгдэх юм бий юу?

Батсүх: Нэг айраг агуулж байсан гэгддэг газар ухсан зоорь гэмээр хонхор нүх бий. Хэдэн жижиг шавар дуганы түүр болов уу, тийм ором байдаг.

Жужа: Тэгэхээр энэ шинэ хийдийг сэргээсэн лам нар тэр хуучин хийдийн шүтээн бурхан ном судрыг өвлүүлсэн үү?

Батсүх: Тэр бараг үгүй дээ. Тахилын нэг хоёр мөнгөн цөгц л байдаг юм. Өөр юмгүй. Хошуу хурлын хийдийн бурхан шүтээн судар ном, эд зүйлс бүгд устгагдсан юм гэнэ лээ.

Жужа: Тэр хуучны лам нараас одоо амьд хүмүүс байна уу?

Батсүх: Байхгүй ээ, бүгд их өндөр настай хүмүүс байсан учир 1999, 2000 оноос өмнө л таалал болгоосон.

Жужа: Танай хийдийн анхны хамба нь ямар хүн байв, өөр ташаалтай лам?

Батсүх: Цэрэннамжил гавж, гэсгүй нь Жанчив лам байсан.

Жужа: Тэгээд дараагийнх нь хамба ямар хүн байсан бэ?

Батсүх: Дараагийнх нь би. 1997 оноос хойш л хамба гэсэн нэрээр ажиллаж байна.

Жужа: Анх танай хийд хэдэн лам хүүхэдтэй эхэлсэн?

Батсүх: Тав зургаан банди, 7-8 өвгөн лам байсан.

Жужа: Танай энэ ойр орчимд энэ Далхын хурал гэж байсан уу, дээр үед?

Батсүх: Өө байсан. Тэр бол Хошуу хурлын жасаа л байсан юм билээ. Малыг нь адгуулж малладаг, 2-3 лам нар дүйнхэн өдрүүдэд хурал хурдаг. Ганц гэр дугантай, тэр нь модоор бариад гадуур нь шавардсан гэр дуган. Харин тэнд Хятадын пүүсийн худалдааны мухлагүүд бүхий том төв байсан гэж хүүчүүл ярьдаг. Одоо тэр худалдааны мухлаг агуулахных нь шавар түүр ором нь байдаг.

Жужа: Танай энэ нутаг чинь хуучин ямар аймаг хошуу вэ?

Батсүх: Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу.

Жужа: Тэгвэл одоогийн энэ Эрдэнэдалай сумтай нэг хошуу юу?

Батсүх: Тийм, харин хошууны төв нь одоо энэ Дэлгэрхангайд байрлаж байсан.

Жужа: Тэгээд энэ хошууны хамгийн сүүлчийн ноён нь ямар хүн байсан бэ?

Батсүх: Лхамсүрэн гэж хүн байсан. 1937 онд баригдаж яваад, шоронд таалал төгссөн гэнэ лээ. Их залуу хүн байсан юм гэнэ лээ.

Жужа: Хошуу хурлын хийдэд цам гардаг байсан үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батсүх: Гардаг байсан гэнэ лээ. 74 цамтай байсан гэж ярьдаг.

Жужа: Хошуу хийдийн орчимд тахилгат уул овоо бий юу?

Батсүх: Байлгүй яахав, энэ урд талын Дэлгэрхангай уулыг эртнээс тахиж ирсэн. Жил бүрийн зуны эхэн сард тахидаг.

Жужа: Хошуу хийдээс алдартай томоохон лам нар гарсан үү?

Батсүх: Энэ Говь Түшээ гүний хошуундаа алдартай хүмүүс байсан гэсэн. Тэдгээрээс Дойд даа лам гэж их алдартай зурхайч лам байсан юм гэнэ лээ.

Жужа: Майдар эргэдэг байсан үү?

Батсүх: Майдар эргэж байсан гэдэг. 81 тохой өндөр майдар бурхантай байсан юм гэнэ лээ.

Жужа: Энэ хийд яг анх хэдэн онд байгуулагдсан юм бол?

Батсүх: Анх хийд 1840, тавиад оны үед л байгуулагдсан юм гэж таамаг байдаг.

Жужа: Энэ хуучин хийдийн шүтээн нь ямар шүтээн байсан юм бол?

Батсүх: Жамсран, улаан сахиус байсан. Одоо ч шинэ хийдийнх бас энэ шүтээн. Наймдугаар Богдыг Төвдөөс анх залж ирэхэд нь энд утган авч байсан юм гэнэ лээ.

Жужа: Энэ Хошуу хийдэд Төвдөөс, Богдын хүрэнээс том лам нар ирж байсан үү?

Батсүх: Ирж байсан байх аа. Би өвгөчүүлтэй яг энэ талаар ярьж байгаагүй болохоор сайн хэлж мэдэхгүй юм.

Жужа: Энэ Далхын хурлын талаар тэнд ямар нэмэлт мэдээлэл байна?

Батсүх: Үгүй ээ энэ Далхын хурал бол Хошуу ноёны ерөөсөө энэ хошууны эд хөрөнгө, мал сүргийг өсгөн үржүүлэх зорилгоор хурал хурдаг байсан гэдэг.

Жужа: Ойр орчимд нь тахидаг уул овоо байна үү?

Батсүх: Одоо энэ хойно Хангийн хүрэм, Мандал овоо, Өлзийт овоо, Төлийн булаг зэрэг тахилгат овоонууд байна даа.

Жужа: Таны нэр хэн бэ, та хэдэн онд төрсөн бэ?

Батсүх: Батсүх, энэ хийдийн хамба. Сүсэгтний холбооны тэргүүн гэж явдаг. 1977 онд төрсөн, одоо манай хийд барилгын /дуганын / их засвар хийжээр бурхан тахилаа хураачихсан байна. Бороо орохоор дээрээс үс гоождог. Иймд энэ зүн энэ засварыг хийнэ.

Жужа: Танд баярлалаа.